



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/45

Хархорин сум

**Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрхийг хангах, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах, хууль тогтоомж, орон нутгийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, хүүхдийн асуудлаарх салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж хамтран ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг дарын 2023 оны А/39 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ